



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/471

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт,  
сурталчилгааг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21, Засгийн газрын 2017 оны Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого батлах тухай 24 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөний дагуу нэгдсэн зохион байгуулалтаар хангаж, иргэдийн хандалт өндөртэй олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/-т даалгасугай.
3. Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл, Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д зөвшөөрсүгэй.
4. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, хийсэн ажлын тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор тус яамны Нийгмийн эрүүл мэндийн газарт цаасан болон цахим хэлбэрээр ирүүлж ажиллахыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

091462



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 11 сарын 22-ны өдрийн  
А/471 дугаар тушаалын хавсралт



**ИРГЭДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хамтран ажиллах нэгж, байгууллага	Хариуцах газар, хэлтэс	Хугацаа	Санхүүгийн эх үүсвэр
1	Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох “Эрүүл мэнд-Эрхэм баян” нэртэй фейсбүүк хуудсыг нээх	-	ЭМЯ, НЭМГ	2017-2018	Дотоод нөөц
2	Фейсбүүк хуудас ажиллуулах, сургалт, сурталчилгааны ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, зохион байгуулах орон тооны ажилтантай гэрээ байгуулах	ЭЗСХ	ЭМЯ, НЭМГ	2017-2018	Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл
3	Иргэдэд мэдээ, мэдээллийг түгээх зорилгоор олон нийтийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж ажиллах	НЭМУТ	ЭМЯ, НЭМГ	2017-2018	Эрүүл мэндийг дэмжих сан, Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл
4	Хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний дагуу иргэд болон зорилтот бүлэгт зориулсан мэдээ, мэдээлэл, тоо баримтаар хангах, телевиз, радио, сонинд ярилцлага өгөх мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтанг тухай бүр оролцуулах ажлыг зохион байгуулах	Орон тооны гэрээт ажилтан	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2018	Дотоод нөөц
5	“Эрүүл мэнд-Эрхэм баян” фейсбүүк хуудсаар мэдээ, мэдээллийг ард, иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах, идэвхижүүлэх	Харьяа ЭМБ-уудын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	Орон тооны гэрээт ажилтан	2017-2018	Эрүүл мэндийг дэмжих сан, Дотоод нөөц

6	<p>Эрүүл мэндийн байгууллагууд үйл ажиллагааны чиглэлийнхээ дагуу олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сард 1-2 удаа ярилцлага, мэдээлэл өгөх</p>	НЭМҮТ	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2018	Дотоод нөөц
7	<p>Харьяа эрүүл мэндийн байгууллага бүр дараах чиглэлээр шторк бэлтгэн, түгээх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Чихрийн шижин өвчин,</li> <li>- Эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөн,</li> <li>- Амны хөндийн эрүүл мэнд,</li> <li>- Зүрх судасны өвчин,</li> <li>- Хавдар,</li> <li>- Нөхөн үржихүйн эрүүл мэнд,</li> <li>- Осол, гэмтэл,</li> <li>- БЗДХ, бэлгийн боловсрол</li> <li>- Сүрьеэ өвчин,</li> <li>- Томуу, томуу төст өвчин,</li> <li>- Архины хортой хэрэглээ, тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах,</li> <li>- Сэтгэцийн эрүүл мэнд болон бусад үйл ажиллагааныхаа чиглэлийн хүрээнд хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх.</li> </ul>	Орон тооны гэрээт ажилтан, ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ	Харьяа эрүүл мэндийн байгууллагууд	2017-2018	<p>Дотоод нөөц,</p> <p>Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төсөл,</p> <p>Эрүүл мэндийг дэмжих сан,</p>